



**"СҮҮ БОНД"-ЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ
ЗАХИАЛГА ХУВААРИЛАХ ЗААВАР**

2017 оны 6 сарын 23 өдөр

Нэг. Зорилго

- 1.1 "ГОЛОМТ КАПИТАЛ УЦК" ХХК (цаашид "Үндсэн андеррайтер" гэх) болон "СҮҮ" ХК-ийн хооронд 2017 оны 5 сарын 09-ний өдөр байгуулсан 17/06 (147) тоот "Санхүүгийн зөвлөх болон андеррайтерийн үйлчилгээний гэрээ", "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХХ (цаашид "МХБ" гэх)-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 6 сарын 19-ний өдрийн A/108 тоот тушаал болон САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО (цаашид "СЗХ" гэх)-ны 2017 оны 6 сарын 22-ны өдрийн №129 тоот тогтоолоор "Сүү" ХК-ийн гаргаж буй өрийн хэрэгсэл (цаашид "Бонд" гэх)-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хуваарилалтыг энэхүү зааврын дагуу зохион байгуулна.

**Хоёр. Бондыг худалдан авах
хүчин төгөлдөр захиалгыг тодорхойлох, хуваарилах**

- 2.1 СЗХ-ны үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий Үнэт цаасны компаниар дамжин МХБ-д ирсэн, дансандаа тухайн захиалгыг хангах бэлэн мөнгөний үлдэгдэл бүхий захиалгыг хүчин төгөлдөрт тооцно.
- 2.2 Бондын захиалгын хуваарилалтыг Үндсэн андеррайтер зохион байгуулж МХБ хяналт тавин ажиллана.
- 2.3 Бондын захиалгыг хуваарилах босго дүн нь хувь хүн бол 1 тэрбум төгрөг, Аж ахуйн нэгж бол 500 сая төгрөг байна.

Гурав. Захиалга авах хугацаа

- 3.1 Бондын захиалга авах хугацаа 2017 оны 6 сарын 27-ны өдрөөс 2017 оны 6 сарын 29-ний өдрийн 12:00 цаг хүртэл үргэлжилнэ.

**Дөрөв. Арилжаанд оролцох захиалгын
хуваарилалт**

- 4.1 Бондын захиалга нь бондын нийт гаргасан дүнгээс давсан тохиолдолд дараах байдлаар хувь тэнцүүлэн хуваарилалт хийнэ.
 - 4.1.1 'Босго дүнгээс доош' дүнтэй захиалгыг бүтэн хуваарилалт хийх байдлаар, хэрвээ 'босго дүнгээс доош' дүнтэй захиалга нийт бондын дүнгийн 80% /наян хувь/-иас давсан тохиолдолд хувь тэнцүүлэх байдлаар;
 - 4.1.2 'Босго дүнгээс дээш' дүнтэй захиалгыг хувь тэнцүүлэх байдлаар;
- 4.2 Хөрөнгө оруулагч хоёр ба түүнээс дээш УЦК-р дамжуулан захиалга оруулах, захиалгыг хэд хэд хуваан байршуулсан тохиолдолд нийт захиалгыг нэгтгэж нийлбэр дүнгээр тооцно.